



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/223/НА-СТА-ТШЗ

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a><br/>Сүхбаатар сум<br/>2025 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br/>Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a><br/>Аудитын менежер: Б.Батмөнх<br/>Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a><br/>Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар<br/>Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

|  |       |
|--|-------|
| 1. Аудитын дүгнэлт.....  | 3-5   |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                 | 6-10  |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....                                    | 11    |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....                                | 11    |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....                                 | 12    |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                             | 12    |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..... | 13    |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                        | 14-15 |
| 4. Аудитын тайлан.....   | 16    |
| 4.1 Ерөнхий зүйл .....   | 16    |
| 4.2 Материаллаг байдал .....   | 16    |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....                               | 16    |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 17    |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....               | 18    |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                              | 19    |
| 5. Аудитын илрүүлэлт .....   | 19-20 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....                       | 21-22 |

### Товчилсон үгийн жагсаалт

|                     |   |
|---------------------|---|
| <b>УСНББОУС</b>     | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт                         |
| <b>АДБОУС</b>       | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                                       |
| <b>БШУЯ</b>         | Боловсрол, шинжлэх ухааны яам   |
| <b>БШУС</b>         | Боловсрол, шинжлэх ухааны сайд  |
| <b>БСШУС</b>        | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд  |
| <b>БШУГ</b>         | Боловсрол, шинжлэх ухааны газар   |
| <b>ЗГ</b>           | Засгийн газар   |
| <b>НДШ</b>          | Нийгмийн даатгалын шимтгэл  |
| <b>ИТХ</b>          | Иргэдийн төлөөлөгчдийн хурал  |
| <b>ТБОНӨХБАҮХАТ</b> | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

САЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН НЭГДҮГЭЭР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
С.ИЧИНХОРЛОО ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/223/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 15.2.2 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Толилуулга” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон,

- Төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй,
- Халаалтын өмнөх онуудын өр төлбөртэй байсан бол тайлант онд нэмж үүсгэсэн бөгөөд өр төлбөр барагдуулах, дулааны тоолуур тавиулах зэргээр халаалт дулааны зардлыг хэмнэх үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй,
- Хөрөнгийн тооллогын үр дүнг баталгаажуулдаггүйгээс санхүүгийн байдлын тайлан, тодруулгад тусгагдсан бараа материалын болон үндсэн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шууд худалдан авах босго үнээс давсан үдийн хоолны материалын худалдан авах ажиллагааг нийтэд ил тод зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 40,366.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 13 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код   | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|-------|---|------------------|------------------|
| I     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   | 402,308,706.74   | 627,646,531.05   |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 178,612,444.83   | 338,962,995.24   |
| 312   | Банкинд байгаа бэлэн мөнгө  | 178,612,444.83   | 338,962,995.24   |
| 3121  | Төгрөг  | 178,612,444.83   | 338,962,995.24   |
| 31211 | Төрийн сангийн харилцах   | 178,612,444.83   | 338,962,995.24   |
| 33    | АВЛАГА  | 698,945.00       | 698,945.00       |
| 331   | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 698,945.00       | 698,945.00       |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ  | 222,997,316.91   | 287,984,590.81   |
| 351   | Түүхий эд материал  | 309,250.00       | 492,500.00       |
| 3513  | Эм боох материал  | 309,250.00       | 492,500.00       |
| 354   | Хангамжийн материал   | 222,688,066.91   | 287,492,090.81   |
| 3541  | Бичиг хэргийн материал  | 12,004,760.20    | 12,118,558.20    |
| 3542  | Аж ахуйн материал   | 142,780,143.69   | 146,866,260.09   |
| 3543  | Сэлбэг хэрэгсэл   | 1,149,999.00     | 3,265,749.00     |
| 3545  | Барилгын засварын материал  | 7,766,657.00     | 9,368,657.00     |
| 3546  | Хүнсний материал  | 1,072,400.00     | 455,000.00       |
| 3547  | Бусад хангамжийн материал   | 57,914,107.02    | 115,417,866.52   |
| II    | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   | 2,766,059,182.57 | 2,818,167,569.95 |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 2,766,059,182.57 | 2,818,167,569.95 |
| 392   | Биет хөрөнгө  | 2,702,865,182.45 | 2,761,131,169.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц  | 2,821,815,400.00 | 2,821,815,400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл   | (514,623,652.24) | (615,378,315.48) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл  | 59,802,400.00    | 59,802,400.00    |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл   | (38,994,445.22)  | (43,518,435.26)  |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 373,659,842.86   | 564,031,270.86   |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл   | (180,832,734.06) | (234,771,461.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 194,527,141.05   | 246,427,837.05   |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл   | (63,534,861.33)  | (85,240,406.91)  |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө  | 30,780,369.00    | 30,780,369.00    |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл   | (20,194,055.85)  | (25,818,203.85)  |
| 39217 | Ном   | 40,459,778.24    | 43,000,716.04    |
| 393   | Биет бус хөрөнгө  | 63,194,000.12    | 57,036,400.16    |
| 39301 | Програм хангамж   | 35,555,430.00    | 35,555,430.00    |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл   | (5,238,429.88)   | (11,396,029.84)  |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө  | 32,877,000.00    | 32,877,000.00    |
| III   | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   | 3,168,367,889.31 | 3,445,814,101.00 |
| IV    | НИЙТ ӨР ТӨЛБӨР  | 392,731,222.63   | 397,103,193.33   |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 392,731,222.63   | 397,103,193.33   |
| 413   | Өглөг   | 392,731,222.63   | 397,103,193.33   |
| 4132  | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | 392,902,925.63   | 397,103,193.33   |
| 4136  | Бусад өглөг   | (171,703.00)     |                  |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг  | (171,703.00)     |                  |
| V     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  | 2,775,636,666.68 | 3,048,710,907.67 |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо   | 2,775,636,666.68 | 3,048,710,907.67 |
| 511   | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 519,308,098.80   | 519,308,098.80   |
| 512   | Хуримтлагдсан үр дүн  | (879,892,064.13) | (606,817,823.14) |
| 5121  | Өмнөх үеийн үр дүн  | (879,892,064.13) | (879,892,064.13) |
| 5122  | Тайлант үеийн үр дүн  |                  | 273,074,240.99   |
| 513   | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 3,136,220,632.01 | 3,136,220,632.01 |
| VI    | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | 3,168,367,889.31 | 3,445,814,101.00 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|---------|--|------------------|------------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)  | 2,822,309,363.34 | 3,691,101,093.30 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 165,853,873.34   | 209,832,893.30   |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  | 165,853,873.34   | 209,832,893.30   |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 10,656,358.00    | 8,966,700.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 3,290,158.00     | 5,000,000.00     |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 7,366,200.00     | 3,966,700.00     |
| 120017  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                           | 127,972,210.00   | 177,069,361.80   |
| 120018  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал                           | 27,225,305.34    | 23,796,831.50    |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  | 2,656,455,490.00 | 3,481,268,200.00 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  | 2,129,588,700.00 | 2,799,803,300.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 2,129,588,700.00 | 2,799,803,300.00 |
| 1311    | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 3,805,990.00     |                  |
| 131105  | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,805,990.00     |                  |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих   | 523,060,800.00   | 681,464,900.00   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/          | 523,060,800.00   | 681,464,900.00   |
| II      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН  | 2,708,203,752.86 | 3,418,026,852.31 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  | 2,708,203,752.86 | 3,418,026,852.31 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 2,573,978,492.86 | 3,273,655,952.31 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  | 1,493,848,931.03 | 2,061,882,618.06 |
| 210101  | Үндсэн цалин   | 1,006,659,839.44 | 1,247,805,577.63 |
| 210102  | Нэмэгдэл   | 410,228,233.04   | 704,308,431.91   |
| 210104  | Урамшуулал   | 76,960,858.55    | 109,768,608.52   |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                               | 198,568,500.00   | 245,090,500.00   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 135,026,600.00   | 155,566,400.00   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 15,885,900.00    | 22,381,000.00    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 12,708,300.00    | 11,190,500.00    |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 3,177,100.00     | 11,190,500.00    |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 31,770,600.00    | 44,762,100.00    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                                    | 578,605,864.08   | 664,752,567.70   |
| 210301  | Гэрэл, цахилгаан   | 12,923,203.99    | 13,621,916.88    |
| 210302  | Түлш, халаалт  | 545,687,932.09   | 621,703,453.12   |
| 210303  | Цэвэр, бохир ус  | 19,994,728.00    | 29,427,197.70    |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал  |                  | 970,100.00       |
| 210604  | Урсгал засвар  |                  | 970,100.00       |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                     | 17,072,862.49    | 31,024,131.53    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж         | 7,366,200.00     | 3,981,600.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 9,706,662.49     | 27,042,531.53    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал  | 285,882,335.26   | 269,936,035.02   |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал  | 98,826,536.73    | 52,825,214.80    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 17,273,205.00    | 24,406,145.80    |
| 210903  | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол   | 169,782,593.53   | 192,704,674.42   |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 134,225,260.00   | 144,370,900.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   | 134,225,260.00   | 144,370,900.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                                     | 107,637,360.00   | 118,132,500.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                      | 26,587,900.00    | 26,238,400.00    |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)   | 114,105,610.48   | 273,074,240.99   |
| IV      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)                                     |                  |                  |
| V       | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)  | 114,105,610.48   | 273,074,240.99   |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|---------|--|------------------|------------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)                                       | 2,667,111,848.00 | 3,490,234,900.00 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 10,656,358.00    | 8,966,700.00     |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  | 10,656,358.00    | 8,966,700.00     |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 10,656,358.00    | 8,966,700.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 3,290,158.00     | 5,000,000.00     |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                    | 7,366,200.00     | 3,966,700.00     |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  | 2,656,455,490.00 | 3,481,268,200.00 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  | 2,129,588,700.00 | 2,799,803,300.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 2,129,588,700.00 | 2,799,803,300.00 |
| 1311    | Нэмэлт санхүүжилтийн орлого  | 3,805,990.00     |                  |
| 131105  | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,805,990.00     |                  |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих   | 523,060,800.00   | 681,464,900.00   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/          | 523,060,800.00   | 681,464,900.00   |
| II      | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)  | 2,510,347,392.52 | 3,329,884,349.59 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  | 2,510,347,392.52 | 3,329,884,349.59 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 2,373,352,192.52 | 3,186,130,849.59 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил  | 1,493,848,931.03 | 2,061,882,618.06 |
| 210101  | Үндсэн цалин   | 1,004,238,913.10 | 1,247,805,577.63 |
| 210102  | Нэмэгдэл   | 412,649,159.38   | 704,308,431.91   |
| 210104  | Урамшуулал   | 76,960,858.55    | 109,768,608.52   |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                               | 198,568,500.00   | 245,090,500.00   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 135,026,600.00   | 155,566,400.00   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 15,885,900.00    | 22,381,000.00    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 12,708,300.00    | 11,190,500.00    |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 3,177,100.00     | 11,190,500.00    |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 31,770,600.00    | 44,762,100.00    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                                    | 515,050,400.00   | 660,552,300.00   |
| 210301  | Гэрэл, цахилгаан   | 12,451,062.30    | 13,621,916.88    |
| 210302  | Түлш, халаалт  | 482,604,609.70   | 617,503,185.42   |
| 210303  | Цэвэр, бохир ус  | 19,994,728.00    | 29,427,197.70    |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал  | 8,010,400.00     | 20,912,600.00    |
| 210604  | Урсгал засвар  | 8,010,400.00     | 20,912,600.00    |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж                     | 20,980,762.49    | 35,464,531.53    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж         | 7,366,200.00     | 3,981,600.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 13,614,562.49    | 31,482,931.53    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал  | 136,893,199.00   | 162,228,300.00   |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал  | 116,440,999.00   | 137,861,100.00   |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 20,452,200.00    | 24,367,200.00    |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 136,995,200.00   | 143,753,500.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   | 136,995,200.00   | 143,753,500.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                                     | 110,407,300.00   | 117,515,100.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                      | 26,587,900.00    | 26,238,400.00    |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                             | 156,764,455.48   | 160,350,550.41   |
| VIII    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                                    | 156,764,455.48   | 160,350,550.41   |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                             |                  | 178,612,444.83   |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                            |                  | 338,962,995.24   |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1   | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            |                                 |                       |                   |   |
| 2   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                                 |                       |                   |   |
| 3   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       |                                 |                       |                   |   |
| 4   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт |                                 |                       |                   |   |
| 5   | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  |                                 |                       |                   |   |
| 6   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                                 |                       |                   |   |
| 7   | Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       |                   |   |
| 8   | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 519,308,098.80                  | 3,136,220,632.01      | (879,892,064.13)  | 2,775,636,666.68                        |
| 9   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                                 |                       |                   |   |
| 10  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       |                                 |                       |                   |   |
| 11  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт |                                 |                       |                   |   |
| 12  | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  |                                 |                       |                   |   |
| 13  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                                 |                       |                   |   |
| 14  | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               |                                 |                       |                   |   |
| 15  | Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       | 273,074,240.99    | 273,074,240.99                          |
| 16  | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 519,308,098.80                  | 3,136,220,632.01      | (606,817,823.14)  | 3,048,710,907.67                        |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код     | Үзүүлэлт   | Төлөвлөгөө       | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/ | Хувь  |
|---------|--|------------------|-----------------------------|--------------------------------------|-------|
| 2       | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                    | 3,680,435,000.00 | 3,329,884,349.59            | 350,550,650.41                       | 90.5  |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  | 3,680,435,000.00 | 3,329,884,349.59            | 350,550,650.41                       | 90.5  |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 3,517,793,400.00 | 3,186,130,849.59            | 331,662,550.41                       | 90.6  |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 2,304,711,400.00 | 2,061,882,618.06            | 242,828,781.94                       | 89.5  |
| 210101  | Үндсэн цалин   | 1,471,819,400.00 | 1,247,805,577.63            | 224,013,822.37                       | 84.8  |
| 210102  | Нэмэгдэл   | 767,641,300.00   | 704,308,431.91              | 63,332,868.09                        | 91.7  |
| 210104  | Урамшуулал   | 65,250,700.00    | 109,768,608.52              | (44,517,908.52)                      | 168.2 |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 288,088,700.00   | 245,090,500.00              | 42,998,200.00                        | 85.1  |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 195,900,400.00   | 155,566,400.00              | 40,334,000.00                        | 79.4  |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 23,047,000.00    | 22,381,000.00               | 666,000.00                           | 97.1  |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 11,523,500.00    | 11,190,500.00               | 333,000.00                           | 97.1  |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 11,523,500.00    | 11,190,500.00               | 333,000.00                           | 97.1  |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 46,094,300.00    | 44,762,100.00               | 1,332,200.00                         | 97.1  |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 660,552,300.00   | 660,552,300.00              | -                                    |       |
| 210301  | Гэрэл, цахилгаан   | 17,697,100.00    | 13,621,916.88               | 4,075,183.12                         |       |
| 210302  | Түлш, халаалт  | 603,432,000.00   | 617,503,185.42              | (14,071,185.42)                      |       |
| 210303  | Цэвэр, бохир ус  | 39,423,200.00    | 29,427,197.70               | 9,996,002.30                         |       |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 20,912,600.00    | 20,912,600.00               | -                                    |       |
| 210604  | Урсгал засвар  | 20,912,600.00    | 20,912,600.00               | -                                    |       |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 63,892,100.00    | 35,464,531.53               | 28,427,568.47                        | 55.5  |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,589,700.00     | 3,981,600.00                | 1,608,100.00                         | 71.2  |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 58,302,400.00    | 31,482,931.53               | 26,819,468.47                        | 54.0  |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 179,636,300.00   | 162,228,300.00              | 17,408,000.00                        | 90.3  |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 155,269,100.00   | 137,861,100.00              | 17,408,000.00                        | 88.8  |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 24,367,200.00    | 24,367,200.00               | -                                    | 100.0 |
| 212     | ТАТААС   | 6,055,100.00     |                             | 6,055,100.00                         |       |
| 2121    | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                               | 6,055,100.00     |                             | 6,055,100.00                         |       |
| 212101  | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                               | 6,055,100.00     |                             | 6,055,100.00                         |       |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 156,586,500.00   | 143,753,500.00              | 12,833,000.00                        | 91.8  |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   | 156,586,500.00   | 143,753,500.00              | 12,833,000.00                        | 91.8  |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 130,348,100.00   | 117,515,100.00              | 12,833,000.00                        | 90.2  |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 26,238,400.00    | 26,238,400.00               | -                                    | 100.0 |
| 1       | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                       | 3,680,435,000.00 | 3,490,234,900.00            | 190,200,100.00                       |       |
| 131     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ  | 2,799,803,300.00 | 2,799,803,300.00            | -                                    |       |
| 131001  | Улсын төсвөөс санхүүжих  | 2,799,803,300.00 | 2,799,803,300.00            | -                                    |       |
| 132     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                       | 681,464,900.00   | 681,464,900.00              | -                                    |       |
| 132001  | Орон нутгийн төсвөөс   | 681,464,900.00   | 681,464,900.00              | -                                    |       |
| 120004  | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                                | 199,166,800.00   | 8,966,700.00                | 190,200,100.00                       |       |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 5,574,800.00     | 5,000,000.00                | 574,800.00                           |       |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 15,000,000.00    | 3,966,700.00                |                                      |       |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих  | 178,592,000.00   |                             |                                      |       |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                  | 178,612,444.83              | (178,612,444.83)                     |       |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    |                  | 338,962,995.24              | (338,962,995.24)                     |       |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх,
- Малчин өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих,
- Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан хамран сургах тойргийн хүүхдийг боловсролын үйлчилгээнд 100% хамруулж, үйлчилгээний чанарыг сайжруулах,
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үе шаттай, үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтанд ахиц гаргах,
- Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах,
- Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг улирал бүр тооцох,
- "Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль"-ийн 10-р зүйлд заасны дагуу мэргэжлийн бүлгийг байгуулж, багшийн мэргэжлийн үндэсний цахим системийг ашиглан багш, ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гаргасан ахиц, үр дүнг тооцох,
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг бүрдүүлж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;

- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор” Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*  
*Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 277,446.3 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/ |                    |                  |
|--|--------------------|--------------------|------------------|
|  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
| Б  | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө                               | 178,612.4          | 338,963.0          | 160,350.6        |
| Авлага                                       | 698.9              | 698.9              | -                |
| Бараа материал                               | 222,997.3          | 287,984.6          | 64,987.3         |
| Үндсэн хөрөнгө                               | 2,766,059.2        | 2,818,167.6        | 52,108.4         |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>3,168,367.8</b> | <b>3,445,814.1</b> | <b>277,446.3</b> |
| Өр төлбөр                                    | 392,731.2          | 397,103.2          | 4,372.0          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 2,775,636.6        | 3,048,710.9        | 273,074.3        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>3,168,367.8</b> | <b>3,445,814.1</b> | <b>277,446.3</b> |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 338,963.0 мянган төгрөг болж 160,350.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 287,984.6 мянган төгрөг болж 64,987.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 200,904.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 16,707.7 мянган төгрөгийн сурах бичиг, Мобиком ХХК-с 7,089.1 мянган төгрөгийн дижитал танхимын хэрэглэгдэхүүн хүлээн авч, үйл ажиллагаанд 159,714.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,818,167.6 мянган төгрөг болж 52,108.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 67,743.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газраас 9,027.3 мянган төгрөгийн зөөврийн компьютер, зурагт, сурах бичиг, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Боловсролын ерөнхий газраас 41,930.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 42,377.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер, ухаалаг дэлгэц, “Smart education” төслийн хүрээнд Мобиком ХХК-с нийлүүлсэн 66,332.9 мянган төгрөгийн дижитал танхимын төхөөрөмж, дагалдах хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 192,704.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,

- Өр төлбөр дансны үлдэгдэл 397,103.2 мянган төгрөг болж 4,372.0 мянган төгрөгөөр өссөн нь санхүүжилт хүрэлцээгүйгээс он дамжсан халаалтын өрийг барагдуулж дуусаагүй, тайлант онд халаалтын өр төлбөр 4,672.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,110,589.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 681,464.9 мянган төгрөг нийт 2,792,054.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 888,380.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,998,970.1 мянган төгрөгөөр, нийт 3,680,435.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 2,799,803.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 681,464.9 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,574.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 178,592.0 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **3,680,435.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 737,076.8 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 39,128.4 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 63,892.1 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 48,283.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,998,970.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 681,464.9 мянган төгрөг, нийт **3,680,435.0** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 3,329,884.3 мянган төгрөгийг зарцуулж, 338,963.0 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,329,884.3 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь үдийн цай хөтөлбөрийн зардлыг 12,833.0 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх зардлыг 11,105.1 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 309,329.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл          | Зөрүү            | Биелэлт /хувиар/ |
|---|-----------------------|--------------------|------------------|------------------|
| <b>Улсын төсвөөс санхүүжих</b>  | <b>2,998,970.1</b>    | <b>2,648,419.4</b> | <b>338,963.0</b> | <b>88.3</b>      |
| 80226 - Байр ашиглалтын үйлчилгээ   | 9,861.1               | 9,861.0            | 0.1              | 100.0            |
| 80233 - Хүүхэд хамгаалал  | 6,385.6               | 6,385.6            | -                | 100.0            |
| 80312 - Сургалт семинар   | 4,555.2               | 4,555.2            | -                | 100.0            |
| 81605 - Эрүүл мэндийг дэмжих  | 6,055.1               | 6,055.0            | 0.1              | 100.0            |
| 81801 - Үдийн цай хөтөлбөр  | 130,348.1             | 117,515.1          | 12,833.0         | 90.2             |
| 81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин                                      | 53,164.7              | 53,164.7           | -                | 100.0            |
| 81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх     | 18,165.1              | 7,060.0            | 11,105.1         | 38.9             |
| 81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр                                   | 9,219.1               | 9,219.1            | -                | 100.0            |
| 81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2,620,101.3           | 2,310,772.0        | 309,329.3        | 88.2             |
| 81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах                              | 109,334.6             | 109,334.6          | -                | 100.0            |
| 81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн                                       | 5,000.1               | 5,000.0            | 0.1              | 100.0            |
| 81848-Сурах бичгийн түрээс  | 3,981.6               | 3,981.6            | -                | 100.0            |
| 81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх                               | 11,210.8              | 5,515.5            | 5,695.3          | 49.2             |
| <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                       | <b>681,464.9</b>      | <b>681,464.9</b>   | <b>-</b>         | <b>100.0</b>     |
| 80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал                               | 681,464.9             | 681,464.9          | -                | 100.0            |
| <b>ДҮН</b>  | <b>3,680,435.0</b>    | <b>3,329,884.3</b> | <b>338,963.0</b> | <b>90.5</b>      |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулаагүй, харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ үдийн цайны 117,458.1 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Шинэдэлгэр” ХХК, “Болжим цайдам” ХХК, “Жин сүр” ХХК, “Туж ананд” ХХК, зэрэг газруудтай гэрээ байгуулж шууд худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хийж, үлдэгдлийг тулган баталгаажуулж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,708,203.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 40,623.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сайхан сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 150 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 20 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээллээгүй байна.

Үүнд: Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 9 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 9 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – 1 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт - 1 удаа

Мэдээлээгүй:

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ үдийн цайны 117,458.1 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Шинэдэлгэр” ХХК, “Болжим цайдам” ХХК, “Жин сүр” ХХК, “Туж ананд” ХХК, зэрэг газруудтай гэрээ байгуулж шууд худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 2: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/52 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 37,988.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 20,895.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 17,093.6 мянган төгрөгийн анги даалт, шагнал урамшуулал олгосон 2 зөрчилд албан шаардлага, худалдан авах ажиллагаа, шилэн данстай холбоотой 2 зөрчил илэрч зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад шилэн данс болон худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 66.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |     | Биелэлт |     |      |
|----------|------------------------|-----|---------|-----|------|
|          | Тоо                    | Дүн | Тоо     | Дүн | Хувь |
|          |                        |     |         |     |      |

|                 |          |                 |          |                 |             |
|-----------------|----------|-----------------|----------|-----------------|-------------|
| Акт             | 2        | 20,895.0        | 2        | 20,895.0        | 100.0       |
| Албан шаардлага | 2        | 17,093.6        | 2        | 17,093.6        | 100.0       |
| Зөвлөмж         | 2        | -               | -        | -               | 0.0         |
| <b>Нийт дүн</b> | <b>6</b> | <b>37,988.6</b> | <b>4</b> | <b>37,988.6</b> | <b>66.7</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **19,377.0** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд зардлыг 16,154.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн,
- Хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгээгүйгээс 410.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэн тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд элэгдлийн зардал 2,812.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### Залруулаагүй алдаа:

1. Хөрөнгийн тооллогын үр дүнг баталгаажуулдаггүйгээс санхүүгийн байдлын тайлан, тодруулгад тусгагдсан бараа материалын эхний үлдэгдэл нь нярвын тайлан дахь үлдэгдлээс 10,424.8 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 331,240.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг баталгаажуулсаны үндсэн дээр хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлж байх зөвлөмж хүргүүлэх.

Аудитаар нийт **20,443.3** мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup>-д албан шаардлага хүргүүлээ.

#### 5.1 Албан шаардлага

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 37 багш, ажилтанд 7,266.8 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1.“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Цалингийн зардлаас нийгмийн даатгалын зардалд 7,464.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 1,039.4 мянган төгрөг, нийт 8,504.1 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тус сургууль нь халаалтын өмнөх онуудын 392,430.8 мянган төгрөгийн өр төлбөртэй байсан бол тайлант онд 4,672.4 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмж үүсгэсэн бөгөөд өр төлбөр барагдуулах, дулааны тоолуур тавиулах зэргээр халаалт дулааны зардлыг хэмнэх үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; 15.2.2 дахь “нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөр барагдуулах арга хэмжээ авах, хэмнэх боломжийг судлан хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                                      | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                 |              |                  | Зөвлөмж  |                  |
|--|------------|------------------|-----------------------------------|----------------|--------------------------|------------------|------------|-----------------|--------------|------------------|----------|------------------|
|  |            |                  |                                   |                |                          |                  | Залруулсан |                 | Залруулаагүй |                  |          |                  |
|  | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн            | Тоо                      | Дүн              | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн              | Тоо      | Дүн              |
| Үр дүнгийн тайланд зардлыг зөрүүтэй илэрхийлсэн        | 1          | 16,154.9         |                                   |                | 1                        | 16,154.9         | 1          | 16,154.9        |              |                  |          |                  |
| Бараа материалыг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн            | 1          | 410.0            |                                   |                | 1                        | 410.0            | 1          | 410.0           |              |                  |          |                  |
| Үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан | 1          | 2,812.1          | 1                                 | 2,812.1        |                          |                  | 1          | 2,812.1         |              |                  |          |                  |
| Хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн              | 2          | 341,665.3        |                                   |                | 2                        | 341,665.3        |            |                 | 2            | 341,665.3        | 2        | 341,665.3        |
| <b>Дүн</b>   | <b>5</b>   | <b>361,042.3</b> | <b>1</b>                          | <b>2,812.1</b> | <b>4</b>                 | <b>358,230.2</b> | <b>3</b>   | <b>19,377.0</b> | <b>2</b>     | <b>341,665.3</b> | <b>2</b> | <b>341,665.3</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |                 |         |     |                                      |     |   |     |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
|  |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                 | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн             | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгэс эс цалинг илүү бодож олгосон | 1           | 7,266.8         |               |     | 1               | 7,266.8         |         |     |                                      |     |   |     |
| Бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан                        | 1           | 8,504.1         |               |     | 1               | 8,504.1         |         |     |                                      |     |   |     |
| Өр бууруулах, хэмнэх боломж бий эсэх талаар дорвитой ажил хийгдээгүй     | 1           | 4,672.4         |               |     | 1               | 4,672.4         |         |     |                                      |     |   |     |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>20,443.3</b> |               |     | <b>3</b>        | <b>20,443.3</b> |         |     |                                      |     |   |     |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                  | Үүнээс        |     |                 |                  |         |     |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|---------|-----|
|  |             |                  | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                  | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн              | Тоо           | Дүн | Тоо             | Дүн              | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил                           |             |                  |               |     |                 |                  |         |     |
| Шилэн дансны цахим санд 20 мэдээллийг хугацаа хоцроож 1 мэдээллийг огт мэдээлээгүй | 1           | -                |               |     | 1               | -                |         |     |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>-</b>         |               |     | <b>1</b>        | <b>-</b>         |         |     |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил                              |             |                  |               |     |                 |                  |         |     |
| Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй                         | 1           | 117,458.1        |               |     | 1               | 117,458.1        |         |     |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>117,458.1</b> |               |     | <b>1</b>        | <b>117,458.1</b> |         |     |
| <b>Нийт дүн</b>  | <b>2</b>    | <b>117,458.1</b> |               |     | <b>2</b>        | <b>117,458.1</b> |         |     |